

ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН ХАРЬЦАНГУЙН ТААМАГЛАЛЫН ФИЛОСОФИ УТГА

Р. Дарьхүү (Доктор Ph.D)

Философи, шашин судлалын тэнхим, МУИС

Б.Өлзийсайхан (Докторант)

НХУС-ийн Нийгмийн ухааны тэнхим, МУБИС

Түлхүүр үг: *Ертөнцийн хэлэн зураглал, хэл ба сэтгэхүй, хэлний кодчилол, тархины үйл ажиллагаа, орон зай ба цаг хугацааны баримжаа*

Товч утга: *Хэл шинжлэлийн харьцангуйн таамаглал нь үүссэн цагаасаа эхлэн янз бүрийн хүрээний судлаачид, түүний дотор философичдын анхаарлыг татсаар ирсэн. Хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалын онцлог, ач холбогдол нь орчин үеийн хэл шинжлэл, сэтгэл судлал, философи зэрэг хүмүүнлэгийн ухааны олон салбарын уулзвар дээр хэлний асуудлыг дэвшүүлэн шийдвэрлэсэн юм. Тухайлбал, Э.Сепир, Б.Уорфын судалгаа нь хүний оршихуйд хэлний язгуур шинж чухал нөлөөтэйг үндэслэж, европ төвт үзлээс татгалзах, хүний оршихуй, сэтгэлгээ, соёлын олон талт байдлыг хүлээн зөвшөөрөх олон ургалч хандлага, ертөнцийн тухай хэлэн зураглалыг шинжлэх, зэрэг асуудлыг шийдвэрлэх шинэ хандлага, өөр өнцгөөс харах боломжийг илэрхийлсэн.*

Ертөнцийн хэлэн зураглалын тухай Э.Сепир, Б.Уорф нарын дүгнэлт нь тухайн асуудлаарх орчин цагийн хамгийн их иш татагддаг эрдэмтэд байх эрхийг өгсөн.

Э.Сепир, Б.Уорф нарын хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалын гол зарчим, үзэл санааг дараах байдлаар тодорхойлж болох юм: Хэл нь сэтгэхүй ба танин мэдэхүйн аргыг тодорхойлдог гэж үздэг. Энэ хандлагад агуулагдаж буй хоёр гол асуудал нь:

А. Хэл шинжлэлийн харьцангуй байдал (өөр өөр хэлээр ярьдаг хүмүүс бодит байдлыг өөр өөрөөр танин мэдэж, тусган ойлгодог)

В. Хэл шинжлэлийн шалтгаан (хэл нь өөрөө энэхүү ялгаатай байдлын шалтгаан нь байдаг).

Хэл шинжлэлийн харьцангуйн зарчимтай харьцуулахуйц дүгнэлтүүд неогумбольдт хандлагын европын (Л. Вейсгербер, И.Трир, Х.Глинц, Г.Ипсен ба бусад) ба америкийн (үүнд Э. Сепир, Б.Уорфоос гадна Д.Хаймз нарын хэсэг хүмүүс багтаж байв) гэсэн хоёр салаа урсгалд боловсруулагдаж байсан. Төстэй үзэл санааг А. Кожибский, К.Айдукевич, Л.Витгенштейн, Л.В.Щерба болон

бусад судлаачид хэлж байв. Б.Уорф “хэл шинжлэлийн харьцангуйн зарчим” гэдэг ойлголтыг А.Эйнштейнийн харьцангуйн онолтой шууд бөгөөд зориудын аналогоор нэвтрүүлсэн хэмээн судлаачид тайлбарладаг.

Б.Уорфынхоор хэл нь нэг талаас ертөнцийг үзэх үзлийг тусгаж, нөгөө талаас тэмдэглэдэг өөр хоорондоо уялдаа холбоотой категориудын систем байдаг. Үгийн сангийн түвшинд хэл тус бүр нь туршлагын зарим салбаруудаа бусдаасаа илүү дэлгэрэнгүй кодчилдог байна. Тиймээс бид хана нь хэлний бүтцийн дүрмээр баригдсан нэг ёсондоо оюун ухааны шоронд амьдарч байгаа аж. Энэ бол маш өвөрмөц шорон юм. Учир нь өөр өөр хэл, соёлтой хүмүүс хоорондоо харилцахад л бид энэ шоронд байгаагаа ойлгодог хэмээн Б.Уорф дүгнэсэн. Төрөлх хэлнээсээ эрс тэс ялгаатай хэлтэй тулгарснаар л тэр хүрээ хязгаараасаа гарах боломжтой ажээ. Өөрөөр хэлбэл, бодит байдал нь хэлний олон талстаар дамжин хугардаг бөгөөд тэрхүү хугарлын хэмжээ нь (хугарлын өнцөг нь) өөр өөр хэлнүүдэд (ард түмнүүдэд) ялгаатай байдаг гэсэн үг юм. Энэ дүгнэлт санаа В.Гумбольдтын бүтээлд мөн илэрдэг. Тухайлбал, Х.Г.Гадамер В.Гумбольдтын онолыг авч үзэхдээ: “ертөнцөд амьдарч байгаа хүн зүгээр нэг багаж, хэрэгсэл мэт

хэлээр тоноглогдсон байдаг биш, харин түүний ертөнц хэлэн дээр үндэслэж, хэлээр илэрхийлэгддэг юм. Хүний хувьд ертөнц гэдэг “энд байх” юм, ертөнцөд амьдарч байгаа өөр ямар ч амьд амьтанд ертөнц нь ийм энд ахуйтай байдаггүй. Гэсэн ч ертөнцийн энэхүү энд ахуй нь хэлний оршихуй байдаг” хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг.¹

Ертөнцийн хэлэн зураглал, хэл шинжлэлийн харьцангуйн зарчимын асуудлаар Э.Сепир, Б.Уорфоос хойшхи эрдэмтэн судлаачид ямар дүгнэлт, судалгаа шинжилгээ хийсэн болохыг харьцуулан авч үзье:

Мехикод болсон Олон улсын философийн 13-р Конгресс (1963) дээр “Хэл шинжлэлийн харьцангуйн онолын философи утга” гэсэн сэдвээр Армений философич Г.А.Брутян илтгэл тавьсан.² Тухайлбал, “Хэл шинжлэлийн харьцангуйн онолын асуудлыг задлан шинжлэх нь хэл шинжлэлийн харьцангуй байдал үүсэх гносеологийн тодорхой язгуур үндсийг харуулж чадах юм. Бидний үзэж буйгаар, зарим тохиодолд Б.Уорфтой санал нийлж, мөн зарим тохиолдолд хэлний нөлөөллийн шинж, хүрээ хязгаар, зэрэглэл төвшинг тодорхойлох тухай асуудлаар маргаж болох боловч асуудлыг өөрийг нь үгүйсгэх учиргүй юм. Б.Уорф болон түүний залгамжлагчид, тэр дундаа ерөнхий семантикийн сургуулийн зарим судлаачдын гавьяаг зүй ёсоор үнэлэх хэрэгтэй. Энэ нь тэд “ертөнцийг хэлээр хүртэн мэдрэхүйн” үүслийн өвөрмөц онцлогуудад, ертөнцийг юуны өмнө хэлний хэрэгслийн сангаар дамжуулан танин мэдэхүй, мөн хүрээлэн буй бодит байдлын тухай тийм ойлгохуй нь хүмүүсийн танин мэдэхүйн хэлбэрүүд хийгээд тэдний үйл ажиллагаанд нөлөөлдөг шинжид онцгой анхаарал хандуулсан явдал юм. Гэхдээ хэл, түүний бүтэц нь дангаараа хүний аль нэг навир үйлдлийг нөхцөлдүүлж, шалтгаацуулж чадахгүй. Энд л хүмүүсийн авир үйлдэлд хэл нөлөөлдөг тухай Уорф болон хэл шинжлэлийн философийн янз бүрийн сургуульд хамаарагч түүний

залгамжлагчдын байр сууринаас бидний ойлголтын ялгарах зарчмын ялгаа оршиж байгаа юм. Ертөнцийг “хэлээр танин мэдэхүйн” асуудлуудыг нарийвчлан судлах нь манай философичдын хойшлуулшгүй зорилт болж байна гэж Г.А.Брутян дүгнэв.

Олон улсын философийн 14-р Конгресс³ (1968) дээр энэ таамаглалын олон талт байдлыг хэд хэдэн илтгэл, хэлсэн үгэнд авч үзсэн байдаг.

Хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалын үндсэн зарчмуудыг философийн хувьд нэгтгэн дүгнэж товчоолсон тайлбарыг хийсэн Польш, АНУ-ын философич, ерөнхий семантикийн төлөөлөгч Альфред Кожибский (1879-1950) “... Аль ч хэл үндэс суурьтаа тодорхой метафизиктэй байдаг, тэр нь ертөнцийн бүтцэд ухамсартай эсвэл ухамсаргүйгээр зарим нэг дүр төрх оруулж байдаг”⁴ (1933) гэж дүгнэв. В.А.Звегинцевын дүгнэлтээр бол А.Кожибскийн ерөнхий семантик бол Сепир-Уорфын таамаглалын туйлын илрэл ажээ.

Ерөнхий семантик болон лингвистик харьцангуй онолын зарчмын чиг хандлагуудын нийтлэг шинжийн тухай АНУ-ын хэл шинжлэлч, ерөнхий семантикийн төлөөлөгч Хайакава (1906-1992) “Ерөнхий семантик бол хэл, сэтгэхүй, авир үйлдлийн өөр хоорондын харилцааны тухай, өөрөөр хэлбэл, бид хэрхэн ярьж байна, түүнээсээ ургуулаад хэрхэн сэтгэж байна, сэтгэлгээндээ тулгуурлаад хэрхэн үйлдэж байна гэдгийн хоорондын харилцааны тухай сургаал юм. Япон, хятад эсвэл турк гэх мэт англи хэлнээс бүтцээрээ эрс ялгаатай хэлээр яригч этгээд нь англи хэлээр ярьж буй хүний сэтгэдэг тухайн ойлголтуудаар нь сэтгэж чадахгүй байж болох юм...”⁵ (1945) хэмээн дүгнэсэн.

Ерөнхий семантикийг тайлбарлагч

¹ Гадамер, Х.-Г. Язык как опыт мира // <http://www.nsk.su/~shev/gadamer.htm>

² Brutian, G. The Philosophical Essence of the Theory of Linguistic Relativity. “Memorias del XIII Congreso Internacional de Filosofia” (Mexico. D.T.7-14 de 1963. Comunicaciones Libres, vol. V Universidad Nacional Autónoma de Mexico)

³ “Proceedings of the XIVth International Congress of Philosophy. Vienna 2nd to 9th September 1968”, vol. I. University of Vienna 1968. Herder Vienna: A.Schaff, Sprache, Denken, Handeln (“Proceedings of the XIVth International Congress of Philosophy. Vienna 2nd to 9th September 1968”, vol. I. University of Vienna 1968. Herder Vienna), E.K.Specht. Die Sapir-Whorf-Hypothese und der Streit zwischen Realismus und Idealismus, E.Riverso. Language as an Interpreting Behaviour (i b i d.), G.Brutian. On Some Aspects of Language as an Object of philosophical Investigation.

⁴ Korzybski, A. (1933). Science and Sanity. p.89

⁵ Hayakawa, S.I. (1945). Language in action. N.Y., Hayakawa, S.I. (1949). Language in Thought and Action. N.Y. p.21

АНУ-ын эдийн засагч, философич Ст.Чейз (1888-1985) “Зөвшилцөлд хүрэх арга замууд” (1951) номондоо АНУ-ын төрийн департаментын гадаад албаны Хүрээлэнгийн эрхэлдэг судалгаа нь “индиан европын болон бусад хэлний бүтцийг зөвхөн тэдгээрийн синтаксисын (өгүүлбэр зүйн) байр сууринаас биш, мөн тэдгээр хэл ямар янзаар сэтгэх, үйлдэл хийхийг хүмүүст тулгаж буй байр сууринаас задлан шинжлэх явдал юм”⁶ хэмээн тэмдэглэсэн байдаг.

Америкийн философич Морис Лазеровец (1907-1987) “философи анализ” гэдэг нь философи нотолгоо, үндэслэгээнүүдийг аливаа нэр томъёоны хэрэглээний дүрэм рүү хандуулах явдал гэж үзээд “ийм үзэл баримтлал ёсоор бол Декартын *cogito* нь яг л “Би” хэмээх биеийн төлөөний үгийг хэрэглэх гол шинж лугаа адил утгынхаа хувьд “дүрэм зүйн аспект” байдлаар орчуулагдах ёстой” гэсэн санал хэлжээ. Тэрээр “Философичдын үзэл баримтлалыг ийм байдлаар тайлбарлах ёстой”⁷ гэж үзсэн бөгөөд “Хэл шинжлэлийн философийн зарим төлөөлөгч лингвистик харьцангуйн онолын байр сууринаас философийн түүхийг хянан үзэх сонирхолтой байдаг” хэмээн дүгнэж байв.

Чарлз Хоккет хэл шинжлэлийн ялгаа, харьцангуйн тухай санааг “Янз бүрийн хэлнүүд нь тэдгээрээр юу илэрхийлж болдогоороо төдийгүй юуг хялбар илэрхийлж болдогоороо ч ялгаатай байдаг”⁸ (1954) хэмээн томъёолжээ.

Боннын их сургуулийн профессор Е.Шпехт “хэл шинжлэлийн харьцангуйн таамаглал нь философийн түүхийн туршид байж ирсэн идеализм ба материализмын дуусашгүй, шийдвэрлэгдэшгүй маргаанаас зайлсхийж, үр дүнтэй зарчмуудыг санал болгосон” хэмээн үзэж байв.⁹ 1951-1952 оны хичээлийн жилд хэлний асуудлаарх Мичиганы их сургуулийн олон салбарын багш нарын судалгааг Рокфеллерын сангаас санхүүжүүлсэн ажээ.¹⁰ Энэхүү

судалгаанд Сепир-Уорфын таамаглалын хүрээнд хэл, сэтгэхүй ба соёлын харилцан хамаарлыг авч үзсэн явдал нь хэлний асуудлыг хүмүүнлэгийн ухааны олон салбарын уулзварт судлах ёстойг улам баталж өгсөн бөгөөд АНУ-ын хэл шинжлэлийн хөгжилд нөлөөлж тухайлбал, сэтгэц хэл шинжлэл, когнитив хандлагын судалгааны үндэс болжээ. Б.Уорфын үндсэн зарчим, дүгнэлтүүд нь басхүү бие даасан судалгаануудын судлагдхуун болсон аж. Зарим судлаач, тухайлбал, К.Клухон, Д.Лейтон, Л.Томсон нар хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалтай санал нэг буйгаа илэрхийлдэг. Харин Э.Леннеберг, С.Фюер болон бусад эрдэмтэд Б.Уорфын аргазүй болон дүгнэлтүүдийг шүүмжлэн ханддаг.¹¹

1954 онд Э.Сепирийн бас нэгэн шавь буюу Уорфын хамтран зүтгэгч Харри Хойер (1904-1976) нь хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалд тусгайлан зориулсан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан¹². Тэр хуралд угсаатны хэл шинжлэлчдээс гадна хүмүүнлэгийн ухааны бусад салбарын төлөөлөгчид (сэтгэл судлаачид, антропологичид, философичид г.м.) оролцсон бөгөөд хэлэлцүүлэгдэж буй таамаглалыг дэмжигчид болон эсэргүүцэгчид нь байв. Энэ үеэс эхлэн Б.Уорфын судалгаа шүүмжлэлд идэвхтэй өртөж эхэлсэн бөгөөд хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалыг батлах эсвэл үгүйсгэх гэсэн оролдлого улам нэмэгджээ.

Сепир-Уорфын хэл шинжлэлийн харьцангуйн таамаглал олон оронд янз бүрийн салбарын мэргэжилтнүүдийн анхаарлыг татсаар ирсэн бөгөөд өргөн хүрээний судалгаанууд хийгдсэн юм. Ялангуяа ертөнцийн хэлэн сураглалын асуудлаар хүмүүнлэгийн ухаануудын уялдаа холбооны үүднээс хийгдсэн судалгааг авч үзвэл:

1955 онд Р.Браун, А.Блеки, А.Горовиц нар хэлний дуудлага дахь бэлгэдлийн (үгийн авиан хэлбэр ба утгын дүйцэл)

⁶ Chase Stuart. (1951). *Roads to Agreement*. N.Y., p.199-200

⁷ M.Lazerowitz. *Studies in Metaphilosophy*. L.-N.Y., 1964, p.56-57

⁸ Hockett, C. (1954). Chinese versus English: an exploration of the Whorfian theses. In: Hoijer H. (Ed.) *Language in culture*. Chicago, University of Chicago Press, p.122

⁹ Specht, E.K. (1968). *Die Sapir-Whorf-Hypothese und der Streit Zwischen Realismus und Idealismus*. Herder Vienna. Конгрессын бүтээлүүдэд хэвлэгдсэнийг үзэх.

¹⁰ “Language, Thought, and Culture”, edited by Paul Henbe. The

University of Michigan Press, Second printing 1966

¹¹ Whorf, B.L. *Language, Thought, and Reality*. Selected Writings. Edited and with an introduction by J.B. Carroll. Cambridge, Mass., p.28

¹² Hoijer, Harry (editor). *Language in culture; conference on the interrelations of language and other aspects of culture*. With papers by F. Fearing, J. H. Greenberg, C. F. Hockett, H. Hoijer, N. A. McQuown, S. Newman, C. F. Voegelin, J. F. Yegerlehner, and Florence M. Robinett. Chicago: University of Chicago Press, 1954. (Also published as Memoir 79 of the American Anthropological Association.)

асуудлаарх судалгааг хэд хэдэн хэлний баримтад түшиглэн хийсэн.¹³ Тэд Англи хэлэн дэх эсрэг тэсрэг утгатай 21 хос үгийг (дулаан-хүйтэн, хүнд-хөнгөн г.м.) гурван хэлэнд орчуулав. Уг туршилтад оролцогчдод тэдний мэдэхгүй хэл дээр бичсэн эдгээр хос үгийг харуулж, энэ нь тэдний төрөлх хэлний ямар эсрэг тэсрэг хос үгтэй дүйж байгааг хэлж өгөв. Туршилтанд оролцогчдын зорилго нь үгийн галигласан (дуудлага харуулсан) бичилтээр нь тус бүрийн орчуулгыг тодорхойлох явдал байв. Тухайлбал, хятад хэлний ch' ing ба eh' ung гэсэн хоёр үгийг өгөөд нэг нь «хөнгөн» гэсэн утгатай, нөгөөх нь «хүнд» гэсэн утгатай гэдгийг хэлж өгчээ. Оролцогч «хятадын» хос үг ба «английн» хос үгсийг дүйлгэх хэрэгтэй байв. Туршилтын үр дүнд ихэнх оролцогч үгийн утгыг зөв «оноосон» бөгөөд шалтгаан нь үгийн авиан бүрэлдэхүүн нь дүрсэлж буй объектынхоо онцлогийг «битүүхэндээ заан хэлж өгч» байв. Туршилтанд оролцогчид санамсаргүй сонголтын боломжоос илүү магадлалтайгаар үгийн утгыг түүний дуудлагатай холбон төсөөлж чаддаг болохыг энэ туршилт ба түүний ижил туршилтууд батлан харуулжээ. Хоёр үгийг хоёуланг нь мэдэхгүй хэлнээс авсан, тухайлбал, нэгийг нь чех, нөгөөг нь хятад хэлнээс авсан тийм үгийн хослолыг ч харуулахад дээрхтэй ижил үр дүн харагдаж байсан ажээ.

Ертөнцийг үзэх үзэл хэлний шинж чанараар нөхцөлддөг тухай хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалын санаа янз бүрийн сургууль, чиглэлийн философичдын дунд олон маргаан үүсгэсэн.¹⁴ Хэл шинжлэлийн харьцангуй байдлыг шалгах зорилгоор Ж.Кэррол, Ж.Касагранде нар 1958 онд өөр өөр хэлээр (англи ба навахо) ярьдаг хүүхдүүд хэлбэрийг хэрхэн ангилдаг болохыг судлах туршилт явуулсан.¹⁵ АНУ-ын Аризона, Нью-Мексико мужийн индианчуудын Навахо хэлний үйл үгнүүд нь

ямар хэлбэртэй эд зүйлтэй (урт ба нимгэн, дугариг - нийт 11 төрлийн хэлбэртэй) үйлдэл хийж байгаагаасаа хамаараад хэлбэрээрээ ялгаатай байдгийг харгалзан үзжээ. Хүүхдүүд хэлбэр, өнгө, материал гэх мэт хэд хэдэн үндэслэлээр ангиллыг хийх боломжтой байв. Навахогоор ярьдаг хүүхдүүд англи хэлээр ярьдаг хүүхдүүдийг бодвол «эд зүйлийн хэлбэр» гэсэн үндэслэлээрх ангиллыг илүү их ашиглах болно гэсэн таамаглал байв. Туршилтаар тэр таамаглал батлагджээ.

1960 онд Ч.Э.Осгуд япон, испани хэлт мексикчууд, навахо болон англичууд үгсийг дүрэн төсөөлөл, зурагтай холбон сэтгэх хандлагатай байдаг болохыг судалгаагаар нотолжээ.¹⁶ (тухайлбал, навахо хэлээр ярьдаг индианчууд «аз жаргалтай» гэдэг үгийг дээшээ харсан сумтай зүйрлэдэг, харин хэзээ ч доошоо харсан сумтай зүйрлэхгүй ажээ.)

1961 онд С.Е.Эш хүмүүсийн сэтгэл зүйн онцлогийг зүйрлэл (метафор) байдлаар тэмдэглэх зорилгоор (тухайлбал, «тэр бол хүйтэн хүн») объектуудын физик шинж чанарыг тэмдэглэдэг үгсийг (хүйтэн, шулуун г.м.) ашиглажээ.¹⁷ Үүний үр дүнд С.Е.Эш ийм зүйрлэлүүд туйлын ялгаатай хэлнүүдэд (иврит, бирман, хятад, грек г.м.) төстэй байдлаар хэрэглэгддэг болохыг олж мэджээ.

Кпелле хэлэнд (Либери) томыг жижигтэй харьцуулах харьцуулалт эрхэмлэгддэгийг анзаарсан Майкл М.Коул судлаачдын хамтаар 1969 онд соёл хоорондын хэмжээ харьцуулалтын ялгаатай байдлын талаарх туршилт явуулжээ.¹⁸ Кпелле хэлэнд хоёр объектыг харьцуулахдаа «-ээс том» гэсэн илэрхийллийг илүүтэйгээр ашиглаж, «-ээс жижиг» гэсэн илэрхийллийг ховор ашигладаг аж. Туршилтын үйл явцыг эхлүүлэхээс өмнө кпелле хүүхдүүд том хэмжээтэй шоог илүү сонирхож, харин

¹³ Brown, R. (1954). Study in language and cognition / R. Brown, E. Lenneberg // Journal of Abnormal and Social Psychology. Vol. 49. P. 454-462, Brown, R., Black, A. H. and Horowitz, A. E. (1955). Phonetic Symbolism in Natural Languages. J. Abnorm. Soc. Psychol. 50 No. 3/388, Brown, R. (1957). Linguistic Determinism and the Parts of Speech. J. Abnorm. Soc. Psychol. 55/1

¹⁴ Dubs, H. H. (1958). Language and Philosophy. "Philosophical review". №68, №3, Asch, S. E. (1958). The metaphor: a psychological inquiry. In R. Tagiuri & L. Petrullo (Eds.), Person perception and interpersonal behavior (pp. 86-94), California: Stanford University Press

¹⁵ Carroll, J. and Casagrande, J. (1958). The Function of Language Classifications in Behavior. Readings in Social Psychology, 3 ed., New York, Carroll, J. (1963). Linguistic Relativity, Contrastive Linguistics and Language Learning, "Iral", vol. I, No. 1

¹⁶ Osgood, C. E. (1960). The cross-cultural generality of visual-verbal synesthetic tendencies. Behavioral Science, 5, 146-169, Osgood, C. E. (1963). Language universals and Psycholinguistics In: Greenberg J. H. Universals of language. Cambridge, The M. I. T. Press, 299-322, Osgood, C. E. (1964). Semantic differential technique in the comparative study of cultures. American Anthropologist, 66 (No. 3, Part 2), 171-200

¹⁷ Asch, S. E. The metaphor: a psychological inquiry. In: Henle, M. Documents of Gestalt psychology. Berkeley, University of California Press, 1961, 324-333

¹⁸ Коул, М. Культура и мышление. Психологический очерк / М. Коул, С. Скрибнер / Пер. с англ. П. Тульвисте, под ред. и с предисловием А. Р. Лурия. М.: «Прогресс», 1977. 262 с

америк хүүхдүүд хоёр шоонд ижил анхаарал хандуулж байгааг тэд анзаарав. Туршилт явуулж дууссанаа дараа хүүхдүүдээс сонголт хийсэн шалтгаанаа тайлбарлахыг хүсчээ. Хэдийгээр америк хүүхдүүд зөв тайлбар өгөх нь тэд туршилтанд аль талын харьцуулалтад сургагдсанаас огт хамаарахгүй байсан ч гэлээ кпелле хүүхдүүд том шоог сонгохоор дасгалжсан тохиолдолд өөрийн хийсэн сонголт тоо тайлбарлахад илүү хялбар байх нь илэрсэн юм. Дээрх жишээнээс бид гадаад ертөнц дэх объектуудыг яаж ялгадаг, түүнчлэн бодит байдлыг тайлбарлахдаа логикийн ямар уялдаа холбоог баримталдагт хэл нь тодорхой байдлаар нөлөөлдөг гэсэн дүгнэлт гаргаж болохоор байна.

Хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалыг турших шалгалтанд олон амжилт гарсан байдаг ч үгүйсгэн шүүмжилсэн туршилт, судалгаа мөн адил олон байдаг.

Хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалыг шүүмжлэгчдийн дундаас Ноам Чомскийн (1928 онд төрсөн) хэлний чадварууд төрөлхийн бөгөөд нийтлэг байдаг хэмээн тунхагладаг түгээмэл дүрмийн онол хамгийн нөлөөтөйд тооцогддог.¹⁹ Энэ дүгнэлт нь гол төлөв хэлний дүрмийн бүтцэд хамааралтай бөгөөд тэр нь өөрийн уг чанараараа бүх хэлэнд ижил байдаг гэж үздэг. Ийм ерөнхий суурийн ачаар хүн дэлхийн ямар ч хэлийг эзэмшиж чаддаг учир нэгэнт л бүх хэлнүүд өөрийн уг үндсээрээ ижил байдаг тул тодорхой хэлний онцлогууд нь хүний сэтгэхүйд нөлөөлдөг гэж ярих ч хэрэггүй гэж дүгнэдэг. Үүсгүүр хэлшинжлэл хэлний төрөлхийн шинж, өгүүлбэрийн гүн ба өнгөн бүтэц, өгүүлбэрийн бүтэц олон хэлний нийтлэг болох тухай, хэлний зөв ба буруу хэлбэр ялгаатай байх тухай үзэл баримтлалыг баталж байв. Гэвч үүсгүүр хэлшинжлэл утгын асуудлыг орхигдуулж, хэлний бодит баримт дээр суурилагагүй цэвэр хэлбэрийн хандлага илэрхийлсэн нь шүүмжлэгдэж, хэлшинжлэлд дараагийн чиг хандлага бий болоход хүрчээ.

Сепир-Уорфын хэл шинжлэлийн харьцангуйн таамаглал ба Н.Чомскийн түгээмэл дүрмийн онол нь философийн хоёр

чиглэл болох релятивизм ба универсализмын онцгой хувилбарууд мөн гэж судлаачид үздэг байна. Энэхүү хоёр чиглэлийн хоорондох гол “байлдааны талбар” нь өнгө заасан тэмдэглэгээний асуудал байв. Энэ нь өнөөдөр ч хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалыг шалгах хамгийн эвтэйхэн салбарт тооцогддог гэж судлаачид үздэг. Өнгө хүлээн авахуйн салбар яагаад эвтэйхэн байдаг вэ гэхээр, үргэлжилсэн өнгөний солонго бараг хэл бүхэнд өөр өөрөөр салангид категориудад хуваагддаг. Үүнээс гадна хэлэн дэх өнгөний ангиллыг объектив байдлаар хянаж болдог, солонгын өнгө тус бүр өөрийн гэсэн «хэмжээтэй» (хэвшсэн ангилалын төрлөөсөө хамаараад эрчим, тод бүдэг, долгионы урт гэх мэт) байдаг. Өөрөөр хэлбэл, тоон байдлаар хэмжигддэг гэсэн үг юм.

Хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалыг өнгө ялгах туршилтын салбарт шалгахдаа релятивистууд өөр өөр хэлэнд өөр өөр байдаг өнгө тэмдэглэх үгийн тогтолцоонд анхаарсан. Бусад хэлний тээгчид өнгийг ялгаатайгаар хүлээн авдаг үндсэн шалтгаан нь энэхүү тогтолцоотой холбоотой юм. Өөр өөр хэлэн дэх өнгөний хэлний тэмдэглэгээ нь түгээмэл (универсаль) хуульд захирагддаг байна.²⁰ Тухайлбал, Сепир-Уорфын таамаглалыг шүүмжилдэг нөлөө бүхий хандлага бол Брент Берлин, Полу Кей нарын судалгаа (1969) юм.²¹ Хорин хэлэнд судалгаа хийсэн Б.Берлин ба П.Кей нар өнгөнүүдийн нэрс эдгээр хорин хэлэнд өөр өөр давтамжтайгаар гарч ирж байгааг анзаарчээ. Тухайлбал «улаан» өнгө бүх хорин хэлэнд байв, «ногоон» - арван есөн хэлэнд, «шар» – арван найман хэлэнд г.м. Цаашдын судалгааныхаа үр дүнд Б.Берлин, П.Кей нар хэлэнд өнгөний категориуд гарч ирж буй дарааллыг санал болгожээ. Энэ онол нь солонгын хуваагдал санамсаргүй байдлаар явагддаггүй, хэлэнд өнгөний нэршил бий болох нь нийтлэг (соёлоос хамаардаггүй), өнгөний нэршил гарч ирэх дараалал нь нилээд нарийн тодорхойлогдсон байдаг болохыг өгүүлж байгаа юм. Түүнчлэн өөрийн судалгаандаа

¹⁹ Бурас, М. Жизнь и судьба гипотезы лингвистической относительности / М. Бурас, М. Кронгауз // Журнал «Наука и жизнь». 2011. № 8.

²⁰ Гончаров, О.А. Лингвистическая детерминация восприятия цветов у русских и коми / О. А. Гончаров, Н. Н. Князев // Психологический журнал Международного университета природы, общества и человека «Дубна». 2010. №2. С. 1-14.

²¹ Berlin, B., Kay P. Berkeley. (1969). Basic color terms: Their universality and evolution., CA: University of California Press

Б.Берлин, П.Кей нар «фокаль өнгө» (үндсэн өнгө) гэдэг нэр томъёог нэвтрүүлсэн. Бусад бүх өнгө нь үндсэн өнгөнүүдэд ойр байгаа түвшнээрээ бүлэглэн зохих категориудыг үүсгэдэг. Өөр өөр соёлын хүмүүс үндсэн өнгөнүүдийг тэдгээрийн хэл кодчлолоос үл хамааран төстэй үндсэн өнгөнүүдийг онцлон ялгах хандлагатай болохыг Берлин, Кей нарын туршилт харуулжээ. Энэ нь өнгө хүлээн авахуй нийтлэг болохыг, хэлний тодорхой онцлогоос хамаардаггүй болохыг өгүүлж байна. Харин энэ нь хэлэн дэх өнгөнүүдийн хэлний кодчлол нь өнгө ялгах болон өнгөний солонгын ангилалд нөлөөлдөггүй гэсэн дүгнэлтийг илэрхийлэв.

Энэ чиглэлд Р.Браун, Э.Леннеберг (1954) нар ч судалгаа хийжээ.²² Тэд аль нэг хэлэн дэх аливаа юмс үзэгдлийн тодорхой ялгааг төвөггүй, амархан илрүүлэх хугацаа, түвшин нь ердийн амьдрал дээр зохих ойлголтын ялгаа гаргах шаарлага хэр зэрэг гардагтай дүйдэг гэж таамаглажээ. Тухайлбал, өнгөний нэр хэдий чинээгээр урт байна төдий чинээгээр түүнийг танихад илүү хугацаа шаардагдаж, төдий чинээгээр хариу нь зөрдөг болохыг Браун, Леннеберг нар өөрсдийн туршилтараа олж тогтоожээ.

Хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалын үндэслэлтэй нотолгоог Ж.Уинавер ба хамтран ажиллагсад (2007) нь хийжээ.²³ Тэд АНУ-ын орос хэлт цагаачид ба уугуул америкчууд буюу орос ба англи хэлтэй хүмүүсээр цэнхэр ба хөх өнгө ялгах туршилт явуулсан бөгөөд орос хэлэнд хөх ба цэнхэр өнгөний ангилал байдаг, харин англи хэлэнд энэхүү хоёр өнгө нь «blue» гэсэн ганц тэмдэглэгээгээр илэрхийлэгддэг гэдэг асуудал дээр уг судалгаагаа үндэслэжээ. Категори хоорондын өнгө ялгах даалгавар нь категори доторхоос илүү түргэн биелүүлнэ хэмээн судлаачид таамаглав. Өнгөний хэл шинжлэлийн категоричлол (нэршил) түүнийг таних хурдад нөлөөлдөг болохыг энэ судалгааны үр дүн, баталсан байна. Тухайлбал, англи хэлт оролцогчид өнгө хооронд ялгаа гаргахдаа орос хэлт оролцогчидтой ойролцоо байжээ. Орос

оролцогчид нь цэнхэр өнгөний хоёр төрлийг ялгахыг бодвол (категори доторх даалгавар) цэнхэр ба хөх өнгийг ялгахдаа (категори хоорондын даалгавар) илүү хурдан хариу үйлдэл үзүүлж байсан нь туршилтын үр дүнд анзаарагдсан. Англи оролцогчдын цэнхэр ба хөх өнгөний ч, цэнхэр өнгөний хоёр төрлийн ялгал ч ойролцоогоор ижил хурдтайгаар явагдаж байсан (аль аль тохиолдолд категори доторх даалгавар). Өнгөний хэл шинжлэлийн категоричлол түүнийг таних хурдад нөлөөлдгийг энэ судалгааны үр дүн, хариу яруу тодоор харуулсан. Харин энэ нь хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалын жинтэй баримт, нотолгоо юм.

О.Жилберт болон түүний хамтрагчид нь (2006) зорилтот өнгөний өдөөгчүүд хүний харааны баруун талын хагас талбайд өгөгдөж байгаа тохиолдолд л, өөрөөр хэлбэл өнгөний мэдээллийн хэл шинжлэлийн категоричлолын дүн шинжилгээтэй холбоотой үг ярианы зүүн тархины бүтцүүдээр боловсруулагдаж байгаа тохиолдолд л категори хоорондын өнгө ялгал нь категори доторх өнгө ялгахасаа давуу байдаг болохыг олж тогтоожээ.²⁴

Түүнчлэн хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалыг функциональ соронзон долгионы томографийн тусламжтайгаар нотолсон зарим баримтыг тархины үйл ажиллагааны судалгаануудаар гаргаж авчээ. Ийм судалгаануудын нэгийг Л.Тан ба хамтран ажиллагсад (2008) нь хийжээ.²⁵ Уг туршилтанд өнгөний мэдээллийг хүлээн авах ба кодчилох даалгаврыг оролцогчдод өгөхтэй зэрэгцээд, тэдний тархины янз бүрийн бүтцийн идэвхийг хэмжиж байсан юм. Оролцогчдын зорилго бол хоёр өөр өнгөтэй квадратыг ялгах байв. Хятад хэлэнд кодчиллын хүнд хөнгөний түвшнээрээ ялгагддаг хоёр өнгийн бүрдлийг туршилтанд ашигласан. Нэг хэсэг нь амархан нэрлэгддэг өнгөнүүдээс бүрдэж байв, хоёр дахь хэсэг нь хятад хэлэнд жирийн нэргүй, нэрлэхэд хэцүү тийм

²² Brown, R. A study in language and cognition / R. Brown, E. Lenneberg // Journal of Abnormal and Social Psychology. 1954. Vol. 49. P. 454-462.

²³ Winawer, J. (2007). Russian blues reveal effects of language on color discrimination / J. Winawer, N. Witthoft, M. Frank, L. Wu, A. Wade, L. Boroditsky // Proceedings of the National Academy of Sciences of the USA. Vol. 104 (19). P. 7780-7785

²⁴ Gilbert, A. L. Whorf hypothesis is supported in the right visual field but not the left / A. Gilbert, T. Regier, P. Kay, R. Ivry // Proceedings of the National Academy of Sciences of the USA. 2006. Vol. 103, № 2. P. 489-494.

²⁵ Tan, L.H. (2008). Language affects patterns of brain activation associated with perceptual decision / L.H. Tan, A.H.D. Chan, P. Kay, P.L. Khong, L.K.C. Yip, K.K. Luke // Proceedings of the National Academy of Sciences of the USA, vol. 105, № 10. P. 4004-4009

өнгөнүүдээс бүрдэж байсан. Туршилтын үр дүнд амархан нэрлэгддэг ба нэрлэхэд хэцүү байдаг өнгөнүүдийг ялгах хурдад онцын ялгаа илрээгүй боловч энэхүү хоёр даалгаврыг биелүүлэх үе дэх тархины идэвхийн ерөнхий дүр зураг нь өөр өөр байсан аж. Хоёр төрлийн өнгийг хоёуланг нь таних нь голцуу дагзны урд хэсгүүдэд ерөнхий тархины цэгүүдийг идэвхжүүлж байсан боловч зөвхөн амархан нэрлэгддэг өнгөнүүдийг танихад л тархины зүүн хагас бөмбөлгийн хальсны зарим хэсгүүд (доод зулайн хэсэг ба чамархайн дээд арын хэсэг) идэвхжиж байв.

Энэ судалгааны үр дүн, хариуг Сепир-Уорфын хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалын нэмэлт баримт, нотолгоонд тооцох боломжтой. Учир нь түүнд өнгөний мэдээллийн хэлний кодчилолтой холбоотой зүүн тархины тодорхой хэсгүүд илэрсэн юм. Түүнчлэн энэ үр дүн, хариу нь нейропсихологийн судалгаануудад ч нотолгоогоо олж байгаа билээ. Зүүн тархины хальсны эдгээр хэсгүүд гэмтсэн тохиолдолд өвчтөн өнгөний аномали байдалд (хүндрэл, бэрхшээл) орж болзошгүй байдаг, өөрөөр хэлбэл өнгө нэрлэхэд хүндрэлтэй болдог гэсэн үг юм.

Үүнээс хойш өөр өөр хэл ертөнцийг яагаад ялгаатай байдлаар дүрсэлдэг болохыг авч үзсэн судалгааны материалууд хэвлэгдэх болов.²⁶

Орчин үед хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалын хандлага, “Нео-Уорф” чиглэлийн эрдэмтэд, тэдний зохиол бүтээлүүд нэмэгдсээр, нэр хүнд нь өссөөр байгаа гэж олон судлаачид дүгнэж байна.²⁷ Тухайлбал:

Стенфордын их сургуулийн сэтгэл зүйн тэнхимийн *профессор* Лера Бродицки нь өөрийн судалгаандаа хэл шинжлэлийн аргуудыг сэтгэл зүйн туршилтын аргуудтай хослуулдаг. Тэрбээр өөр өөр соёл дахь цаг хугацааны талаарх төсөөлөл, орон зайн зүйрлэлүүдийг хэлний асуудалтай харьцуулан судалсан.²⁸

²⁶ Guy Deutscher. /1st ed./Through the language glass: why the world looks different in other languages.. (2010). Metropolitan Books Henry Holt and Company, New York, Matsumoto, D., Juang, L. 5th edition (2013). Culture and psychology. Printed in the United States of America

²⁷ Gumperz, J., Levinson, S. (eds.). Rethinking linguistic relativity. Cambridge, 1996

²⁸ Boroditsky, L. (2000). Metaphoric Structuring: Understanding

Манчестерийн их сургуулийн профессор израилийн эрдэмтэн Гай Дейчер 2010 онд “Хэлний толины тусгал: Өөр өөр хэлэнд ертөнцийг яагаад ялгаатай хардаг вэ” хэмээх өвөрмөц нэртэй шинжлэх ухааны номыг хэвлүүлсэн.²⁹ Уг номондоо хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалд яригддаг олон асуудлыг харьцуулан судалжээ. Дэлхийн олон янзын хэлэнд зүйрлэл, утга, үгсийн ангилал, өнгө заасан нэрийн асуудал ялгаатай байгааг онцгой анхааран судалжээ.

Америкийн хэл шинжлэлч, сэтгэл зүйч, Чикагогийн их сургуулийн профессор Жон Люси хэл, сэтгэхүй хоёрын уялдаа холбоог судалжээ. Тухайлбал, өнгөний ой тогтоолт, юкатек хэлний нэрийн категоричлолын асуудлыг судалж, юкатек хэлний тооны дүрмийн категори ба тооллын ангиллын систем нь юкатек хэлний тээгчид юмс, үзэгдлийг юуны түрүүнд материалаар нь ангилдаг болохыг батлав. Гэтэл Англи хэлний тээгчид юмс, үзэгдлийг хэлбэрээр нь ангилдаг байна.³⁰

Макс Планкийн Психоллингвистикийн нийгэмлэгийн хүрээлэнд (Неймеген, Нидерланд) ажилладаг Стивен Левинсон хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалын орчин үеийн ач холбогдол³¹ болон янз бүрийн соёл дахь орон зайн утгын илэрхийлийг судалжээ.³²

ОХУ-ын Байгаль, хүн ба нийгмийн “Дубна” их сургуулийн сэтгэл судлалын шинжлэх ухааны доктор, профессор О.А.Гончаров ертөнцийн хэлэн зураглалын асуудал, хэл шинжлэлийн харьцангуйн

time through spatial metaphors // Cognition. № 75(1). P. 1–28. Dils, A.T., Boroditsky, L. Processing unrelated language can change what you see // Psychonomic Bulletin & Review. 2010. № 17 (6). P. 882–888. Fuhrman, O., Boroditsky, L. Cross-Cultural Differences in Mental Representations of Time: Evidence from an Implicit Non-Linguistic Task // Cognitive Science. 2010, 34 (8). P. 1430–1451.

²⁹ Deutscher, G. (2010). Through the language glass: Why the world looks different in other languages. New York.

³⁰ Lucy, J.A. Linguistic Relativity // Annual Review of Anthropology. 1997. № 26. P. 291–312. Lucy, J.A., Shweder R. Whorf and his critics: Linguistic and nonlinguistic influences on color memory // American Anthropologist. 1979. № 81(3). P. 581–615. Reprinted in R. W. Casson (ed.), Language, Culture, and Cognition. New York, 1981. P. 133–63. Lucy, J.A. The scope of linguistic relativity: An analysis and review of empirical research // Gumperz, J., Levinson, S. (eds.). Rethinking linguistic relativity. Cambridge, 1996. P. 37–69.

³¹ Gumperz, J., Levinson, S. Rethinking Linguistic Relativity Current Anthropology. 1991. № 32 (5). P. 613–623.

таамаглалд хамааралтай цуврал туршилтыг явуулсан. Судалгаа нь төрөлх хэлэн дэх өнгө заасан нэр (категоричлол), категори хоорондын ба категори доторх өнгө ялгах хурдад хэрхэн нөлөөлдөг болохыг судлахад, түүнчлэн хөндлөнгийн аман ба аман бус мэдээлэл категоричилсон өнгө ялгах үйл явцад нөлөөлдөг эсэхийг судлахад чиглэжээ.³³ Тухайлбал:


О.А.Гончаров ба хамтрагч нар нь категоричилсон өнгө ялгалд зориулсан цуврал судалгаандаа дээр дурьдсан туршилтыг (Уинавер нар., Джилберт нар) арай өөр аргаар хийжээ. Компьютерийн дэлгэцэн дээр үзүүлж буй дүрс нь 12 квадратаас бүрдсэн тойргийн байдалтай оршино. Оролцогчийн зорилго товчлуурын сумнуудын тусламжтайгаар өнгөөрөө бусад 11 квадратаасаа ялгаатай байгаа тэр дүрс дэлгэцийн аль хэсэгт (баруун эсвэл зүүн) байгааг заах явдал юм. Дэлгэцэн дээр дүрс гарч ирэх ба зохих товчин дээр дарах хоорондын хугацааны интервалыг компьютерийн программ бүртгэж авах байв.

Эхлээд оросууд ба комичуудын өнгө ялгах хэлний шалтаацлын туршилтыг явуулжээ. Ж.Уинаверийн туршилтын нэгэн адилаар судалгааг цэнхэр-хөх өнгийн хүрээнд явуулав. Учир нь коми үндэстэнд англи хэлтнүүдийн нэгэн адилаар цэнхэр өнгийн хүрээг хоёр өнгөнд (хөх ба цэнхэр) ангилан ялгах шинж байдаггүй аж. Дэлгэцээр үзүүлж буй дүрсүүд нь хөх өнгөтэй, харин зорилтот дүрс нь нэг бол ногоон, нэг бол цэнхэр өнгөтэй байв. Комичуудыг бодвол орос хэлтнүүд өнгө

ялгах даалгаврыг илүү түргэн биелүүлж байжээ. Коми хэлэнд цэнхэр ба хөх өнгө нэг үгээр тэмдэглэгддэг. Энэ нь уг даалгаврыг категори доторх зэрэглэлд аваачиж, улмаар илүү хугацаа шаарджээ. Категори хоорондын ба категори доторх эрэл хайгуулын хугацаа олон туршилтаар ялгаатай байгаа нь “хүн өнгийг хүлээн авахуйд хэл нөлөөлдөг нь нотлогджээ.

Өнгө ялгах нь өнгөний хэлний кодчлолоос хамаардаг болох нь туршилтаар нотлогдсоны дараа туршилтаа өөрчилж өнгөний хүрээний нийлбэрийг улаан-улбар шар ба шар-ногоон солонгоор өргөжүүлсэн байна. Цаашлаад тэд (О.А.Гончаров ба хамтрагч нар нь) томоохон судалгааг явуулсан бөгөөд үүнд орос хэлтнүүд болон комичуудын өнгөний категори хоорондын ба категори доторх ялгалд насны өөрчлөлт нөлөөлдөг эсэхийг зорилго болгон судалжээ. Өнгөний ялгааны хэлний кодчлол нь нас ахих хирээр категори хоорондын ялгааг илүү түргэн хайхад хүргэж, харин категори доторх ялгаа нь насны өөрчлөлтөд арай бага өртдөг гэдгийг анзаарав. Өөрөөр хэлбэл коми хүүхдүүд категори хоорондын ба доторх ялгааг оройлцоогоор ижил хурдтайгаар олдог, харин ахлах бүлэгт бол категори хоорондын эрэл хайгуулын хугацаа мэдэгдэхүйц байдлаар богиносдог ажээ.

Компьютерийн тусгай программын тусламжтайгаар туршилтанд оролцогчид дүрснүүдийг үзүүлдэг байна. Судалгаануудад дүрс нь дараах байдлаар харагдаж байв (зураг 1). Оролцогч өнгөөрөө ялгаатай анхдагч дүрс тойргийн аль талд байгааг (зүүн эсвэл баруун) заах даалгавартай байв.



Зураг 1. Өмнөх судалгаанд дүрсийг харуулах арга

³³ Гончаров, О.А. (2010). Лингвистическая детерминация восприятия цветов у русских и коми / О.А.Гончаров, Н.Н.Князев // Психологический журнал Международного университета природы, общества и человека «Дубна». №2. С. 1-14. Гончаров, О.А. (2012). Языковые и возрастные аспекты категориального восприятия цвета / О.А.Гончаров, Н.Н.Князев // Культурно-историческая психология. № 3. С. 40-48. Гончаров, О.А. (2013). Категориальные эффекты различения цветов. Ч. 1. Лингвистический аспект / О.А.Гончаров, С.Г.Романов // Психологический журнал Международного университета природы, общества и человека «Дубна». №2. С. 25-41. Гончаров, О.А. (2013). Категориальные эффекты различения цветов. Ч. 2. Функциональная асимметрия и нарушения речевого развития / О.А.Гончаров, С.Г.Романов // Психологический журнал Международного университета природы, общества и человека «Дубна». № 4. С. 13-36. Гончаров, О.А., (2014). Гипотеза лингвистической относительности: теоретический анализ и эмпирические данные. / О.А.Гончаров, Т.В.Терещенко // Психологический журнал Международного университета природы, общества и человека «Дубна». № 2, С. 11-24

Туршилтанд оролцогчдын хариултад ялгаа тогтоожээ. Дүрсүүдийг 3х3 матрицад байрлуулсан аж. Оролцогчид өгсөн даалгавар нь зохих товчны тусламжтайгаар дэлгэцэн дээр анхдагч дүрсийн яг байгаа байршлыг нь заах явдал байв. Үүний тулд нэмэлт төхөөрөмж хэрэглэв. Дэлгэц дээр дүрслэгдсэн байгаа квадратуудтай дүйх тоон блокууд хэрэглэжээ (зураг 2). Түүнчлэн судалгааны зорилтоос үүдээд дэлгэцийн квадратууд болон тоон блокууд дээр хөндлөнгийн өдөөгчүүдийг байрлуулсан байна (орон зайн тэмдгүүд, үсэгнүүд эсвэл цифрүүдийг). Юуны тулд ийм шинэ туршилтыг хэрэглэсэн бэ гэхээр, янз бүрийн хөндлөнгийн мэдээлэл (орон зайн эсвэл үгэн нөлөөлөл) өнгө ялгах хурдад ямар нөлөөлөл үзүүлдгийг шалгах зорилго байжээ.



Зураг 2. Дээрх судалгаан дахь дүрснүүдийг үзүүлэх арга

Туршилтын үед оролцогч компьютерийн эсрэг талд, түүний гар нь компьютерт залгасан тоон блок дээр байрласан аж. Туршилтын цуврал тус бүрийг явуулахаасаа өмнө оролцогчид зааварчилгааг өгч байв: «Дэлгэц дээр 3х3 матрицын байдалтай есөн квадрат гарч ирнэ. Квадрат тус бүр тодорхой тэмдгээр тэмдэглэгдсэн байгаа. Нэг квадрат нь бусдаасаа бага зэрэг ялгаатай байгаа. Өнгөөрөө ялгаатай нэг квадратыг аль болох түргэн олоод тоон товчлуурын зохих тэмдэгтэй товчин дээр дарах хэрэгтэй». Дөрвөн цуврал тус бүрийг явуулсны дараа туршигч тоон блокийг сольж байв (учир нь хөндлөнгийн өдөөгчүүдийг сольж байсан). Дэлгэцэн дээр өдөөгч гарч ирэх ба товчин дээр дарах хүртэлх хугацааны интервалыг компьютерийн программ бүртгэж авч

байсан, өөрөөр хэлбэл оролцогчийн хариу үйлдлийн хугацааг хэмжиж байсан юм.

Туршилт бүхэлдээ оролцогч тус бүрт 24 цувралаас бүрдэж байв (хөндлөнгийн нөхцөл тус бүрт 8 – чимээ шуугиангүй, үсэг, цифрүүд, тус бүр дотороо – категори хоорондын ялгалын 4 цуврал ба категори доторх ялгалын 4 цуврал, эдгээрээс тус тус 2 цуврал нь захын ба тус тус 2 цуврал нь үндсэн өнгийнх). Цуврал тус бүр нь 20 сорилоос бүрдэж байжээ. Найман цуврал тус бүрийг явуулсны дараа туршигч тоон блокийг сольж байсан. Оролцогч бүх хөтөлбөрийг биелүүлэхэд ойролцоогоор 15 минут зарцуулжээ. Судалгаанд нийтдээ 36 насанд хүрсэн хүн оролцсон ажээ.

Үндсэн өнгөнүүдийн ялгааг олох даалгавар нь хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалыг шалгахад ихээхэн ач холбогдолтой байдаг. Э.Хейдер, Б.Берлин ба П. Кей, Р.Браун ба Е.Леннеберг нар завсрын өнгөнүүдтэй харьцуулбал үндсэн өнгөнүүдийн нэрсийг судлах, боловсруулах, тогтоох, таних зэрэг үйлдэл нь илүү хялбар байдаг болохыг нотолсон бөгөөд хэлэнд үндсэн өнгөний тусгай тэмдэглэгээ үгүй байх нь ч асуудал биш аж.³⁴ О.А.Гончаровын судалгаа ч мөн дээрх дүгнэлтийг батлав. Ийнхүү хэл шинжлэлийн харьцангуй байдал нь үндсэн өнгөнүүд дээр “ажилладаггүй” гэж тэд дүгнэв. Тэдгээр нь захын өнгөнүүдийг бодвол илүү их ялгагддаг учраас тэгж байна уу эсвэл тэдгээрийг таньж тогтоох механизмууд нь ямар нэг зүйлээрээ ялгаатай байдаг учраас тэгж байна уу гэдэг нь одоохондоо ойлгомжгүй байна гэж үзжээ.

³⁴ Heider, E. (1972). Universals of color naming and memory / E. Heider // Journal of Experimental Psychology. Vol. 93. P. 10-20

ДҮГНЭЛТ

Сүүлийн хорин жилд гадаадын нэр хүндтэй хэвлэлүүдэд ертөнцийн хэлэн зураглалын тухай, хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалын сэдвээр, хэл, соёл, сэтгэхүйн уялдаа холбоот байдлын асуудлаар олон нийтлэлүүд хэвлэгдэж байна.³⁵ Өнөөгийн барууны Нео-Уорфчууд судалгаандаа утгын дүн шинжилгээ болон сэтгэц хэл шинжлэлийн туршилтын арга, хэл шинжлэлийн философи арга зүйг их ашиглах болов. Дээрх судалгаануудад өөр өөр хэлээр ярьдаг хүмүүсийн цаг хугацаа, орон зайн баримжаа, метафор, сэтгэл хөдлөл, ойлголтын онцлогыг туршин судлах, тайлбарлах хандлага онцгой байр суурийг эзэлдэг.

Хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалыг баталсан ба үгүйсгэсэн өнгө таних, ялгах туршилт, олон янзын судалгаанууд хийгдсэн байдгаас үүдээд эрдэмтэд ийм судалгаануудыг хийх нь оновчтой эсэхэд эргэлзэх болжээ. Бусад салбарт хийгдсэн судалгаанууд нь дан ганц, ижил утгат үр дүн, хариунд хүргэж чадаагүйг зарим судлаач онцолдог. Дээр өгүүлснийг дүгнээд хэлэхэд, хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалыг шалгах зорилготой олон тооны туршилт, судалгаанууд байдаг ч гэлээ энэ таамаглал нь туршилтын судалгаануудын асар их зөрүүтэй үр дүн, хариуны улмаас онолын статустай хэвээрээ байгаа юм (нотлогдоогүй, үгүйсгэгдээгүй).

Ямар учраас ийм зөрчилтэй үр дүнгүүд байна вэ? Энэ асуултад өгч болох нэг хариуг АНУ-ын социологич, хэл шинжээч **Жошуа Фишман** (1926-2015) өгсөн. Тэрбээр 1960 онд хэл шинжлэлийн харьцангуйн онолын асуудлыг ангилсан. Тухайлбал, тэрбээр 4 түвшнийг дүрсэлсэн бөгөөд тус бүр нь дараах хоёр хүчин зүйлийн харилцан үйлчиллээр тодорхойлогддог.

1. Хэлний судлагч тал (I, II түвшин – үгийн сан, III, IV – дүрэм, өгүүлбэр

³⁵ Gumperz, J., Levinson, S. (eds.). Rethinking linguistic relativity. Cambridge, 1996. Niemeier, S., Dirven, R. (eds). Evidence for linguistic relativity. Amsterdam, Philadelphia, 2000. Stroinska, M. (ed.). Relative points of view: linguistic representation of culture. New York, 2001. Gentner, D., Goldin-Meadow, S. (eds.). Language in mind. Advances in the study of language and cognition. Cambridge, 2003. O'Neill, S. Cultural contact and linguistic relativity among the Indians of Northwestern California. Oklahoma City, 2008.

зүй)

2. Ухамсрын үйл ажиллагааны төрөл (I түвшин – хэл шинжлэлийн үйл хөдлөл, II-IV түвшнүүд – хэл шинжлэлийн бус).

3 ба 4-р түвшин нь хамгийн өндөр түвшин бөгөөд Сепир-Уорфын **онолын сонгодог хувилбарт хамгийн сайн дүйдэг гэнэ**. Энэ онолын асуудлыг судлах ихэнх туршилтууд 2-р түвшинд явагддаг (хэлний ялгаа, үг ярианы зөрүү нь зан үйлд нөлөөлөх). Гэвч үг ярианы ялгаа, зөрүү нь хэт өнгөцхөн байдаг бөгөөд Сепир-Уорфын онолд зөвхөн хэсэгчилсэн нотолгоо болон үгүйсгэлийг өгдөг гэжээ.

Бид хэлний өгүүлбэр зүйн ба дүрмийн онцлог ертөнцийг таних аргуудтай ямар уялдаа холбоотой байдгийг судалснаар ач холбогдлоорой илүү далайцтай бөгөөд сонирхолтой үр дүн, хариуг гаргаж авах боломжтой хэмээн Ж.Фишман дүгнэсэнтэй санал нэг байна. Гэхдээ хэл шинжлэлийн харьцангуйн таамаглалыг туйлшруулах биш, харин онол, арга зүй, практик ач холбогдлыг нь мартах учиргүй юм.

Орчин үеийн хэл шинжлэлийн философичид метафорыг сэтгэхүйн үндсэн үйл ажиллагаа, ертөнцийг танин мэдэх, тайлбарлах, бүтэцчилэх арга гэж үзэх болсон. Хүн метафорын тусламжтайгаар өөрийн санааг илэрхийлээд зогсохгүй, метафороор сэтгэж, метафорын тусламжтайгаар өөрийн ертөнцийг үүсгэдэг учир хэл, сэтгэлгээний онцлог шинжийг хамгийн тодорхой илэрхийлдэг хүчин зүйлсийн нэг юм. Тиймээс метафороор бүтсэн зүйр цэцэн үг, өвөрмөц хэлц, тогтвортой хэллэгүүдийг судлах явал өнөөгийн Неогумбольдт, Нео-Уорф хандлагын судлаачдын сонирхлыг татах болов. Үндэсний онцлогтой үг, хэллэг нь тухайн хэлээр харилцагч үндэстний соёлынх нь өвөрмөц онцлог, сэтгэлгээнийх нь өвөрмөц илэрхийлэл байдаг учраас аль ч хэлбэрээр орчуулж, дүйлгэж “нутагшуулсан” хэлц, хэллэгийн цаана тухайн үндэстний соёлын учир холбогдлыг илэрхийлдэг хамсгал утга (культурная коннотация) орхигдоход хүрдэг байна. Энэ нь метафороор бүтсэн тогтвортой хэллэгүүдийг өөр хэлэнд орчуулна гэдэг төвөгтэй бөгөөд хэл бүхэн авир араншинтай,

метафизиктэй, микрокосмтой гэдгийг баталж байгаа юм.

НОМ ЗҮЙ

1. Брутян Г.А. (1969). О гипотезе Сепира-Уорфа. // Вопросы философии. № 1.
2. Бурас.М, Кронгауз М., (2011). Жизнь и судьба гипотезы лингвистической относительности. // Наука и жизнь. № 8. С.66-72
3. Гончаров О.А, Терещенко Т.В., (2014). Гипотеза лингвистической относительности: теоретический анализ и эмпирические данные. // Психологический журнал Международного университета природы, общества и человека «Дубна». № 2. С.11-24
4. Дойчер Г. (2014). Сквозь зеркало языка. Почему на других языках мир выглядит иначе. (Перевод. Н. Жуков).
5. Рысцо М.М. (2014). (Institute of Linguistics, Russian Academy of Sciences). Неогумбольдтианская лингвистика и рамки “языковой картины мира”. Политическая лингвистика. Издательство: Уральский государственный педагогический университет (Екатеринбург). №1. С.12-24.
6. Edward Sapir. Selected Writings in Language, Culture and Personality. Edited by David G. Mandelbaum. University of California press.,1985

ABSTRACT

The fact of the matter is that the “real world” is to a large extent unconsciously built up on the language habits of the group. No two languages are ever sufficiently similar to be considered as representing the same social reality. The worlds in which different societies live are distinct worlds, not merely the same world with different labels attached. When Semitic, Chinese, Tibetan, or African languages are contrasted with our own, the divergence in analysis of the world becomes more apparent.

The principle of linguistic relativism has a long history in which various important methodological turning points can be identified, exhibiting continually increasing levels of empirical scrutiny.